

ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГТ ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУД, ТЭДГЭЭРИЙН НӨЛӨӨЛӨЛ

*Б.Батжаргал**

Хятад улсын эдийн засгийн бодит өсөлт 2004 онд 9.5 хувьд хүрсэн нь сүүлийн найман жилийн хамгийн өндөр үзүүлэлт юм. Энэхүү өсөлт нь эдийн засагт бүгцийн шинжтэй хүндрэлтэй асуудлуудыг үүсгэж байгаагаас Хятадын Засгийн газар эрчим хүчний хомсдлыг арилгаж, инфляцийг бууруулах зорилгоор төмөрлөгийн болон автомашины үйлдвэрлэлийг хязгаарлах зэрэг бодлогын олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Хятад улс 2005 онд эдийн засгийн бодит өсөлтийг бууруулан 8 хувь, инфляцийг 4 хувьд хүргэхээр төлөвлөжээ.

Хятад улс яагаад эдийн засгийн өсөлтийн хурдцаа бууруулахыг зорьж байна вэ?

Хятад улсын эдийн засгийн хурдацтай өсөлт, зарим үйлдвэрлэлийн салбарын уялдаагүй хэт өсөлт зэргийн улмаас зэс, төмөр, цемент, нүүрс, цайр, хөнгөн цагаан, вольфрам гэх мэт олон төрлийн ашигт малтмал, түүхий эдийн эрэлт, хэрэгцээ асар хурдацтай нэмэгдэж улмаар дээрхи ашигт малтмалыг боловсруулах үйлдвэрүүд олноор байгуулагдах болсон.

Жил бүр Хятад руу орж буй 50-60 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалтын хүрээнд олон тооны барилга байгууламж, үйлдвэрүүд барьж байгуулж байгаа нь үл хөдлөх хөрөнгийн барилгын салбарыг асар хурдацтай өсөхөд хүргэж байна. Эдгээр гадаадын хөрөнгө оруулагчид болон улам бүр хөрөнгөжиж буй хятад иргэдийн орон сууц худалдан авах хэрэгцээ асар ихээр нэмэгдэж байгаа учраас Бээжин, Шанхай зэрэг хүн ам ихээр төвлөрсөн томоохон суурин газруудад барилга барих газрын үнэ огцом өсч (орон сууцны нэгж талбайн үнэ 1500-4000 ам.доллар) улмаар орон сууцны томоохон цогцолборууд олон тоогоор баригдаж байна. Хятад улсын үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт өмнөх онтой харьцуулахад 2004 онд 28 хувиар өссөн байсан бол 2005 онд бууруулж 16 хувиар өсгөхөөр төлөвлөжээ.

Ашигт малтмалын боловсруулах үйлдвэрүүд болон үл хөдлөх хөрөнгө, барилгын үйлдвэрлэлүүд цахилгаан эрчим хүч ихээр хэрэглэдэг салбарууд тул эдгээр салбарын хурдацтай өсөлтийн улмаас Хятадын томоохон аж үйлдвэрийн бүсүүд эрчим хүчний дутагдалд орж

* Б.Батжаргал - Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны гуравдугаар нарийн бичгийн дарга

байна. Сүүлийн хоёр жилийн туршид Хятад улс эрчим хүчний хэрэглээнийхээ 30 гаруй хувийг найдвартай хангаж чадахгүй байна. Хятад улс эрчим хүчнийхээ нийт хэрэглээний 70 гаруй хувийг нүүрснээс цахилгаан гарган хангадаг тул нүүрсний хэрэглээ, тээвэрлэлт, үнэ мөн асар хурдацтай өсөн нэмэгдэх болсон.¹ Хятад улсын нүүрсний эрчим хүчний технологи нь үр ашиг муутай бөгөөд нэг ам.долларын ДНБ үйлдвэрлэхэд дэлхийн дунджаас 3 дахин илүү их хэмжээний эрчим хүч зарцуулдаг гэсэн тооцоо байдаг байна.

Үйлдвэрлэл нэмэгдэхийн хэрээр төмөр замын ачаа эргэлт нэмэгдэж төмөр зам ачааллаа даахгүйд хүрч байна. Үүний улмаас нүүрс тээвэрлэлт доголдож, цахилгааны хомсдол улам бүр хүндрэлтэй болж байна. Аж үйлдвэр түлхүү хөгжсөн бүс нутгуудад төмөр замын тээвэрлэлтийн асуудал хамгийн хүнд асуудлуудын нэг болоод байна.

Эдийн засгийн хурдацтай өсөлтийг даган газрын тосны хэрэглээ асар хурдацтай нэмэгдэж, улмаар газрын тос, хэрэглээний болон үйлдвэрлэлийн барааны үнийн индекс улам хурдацтай нэмэгдэж байна. Сүүлийн үед газрын тос болон ашигт малтмалын бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ нэмэгдэх болсон нь Хятад улс дахь эрэлт хэрэгцээ огцом нэмэгдэж буйгаас ихээхэн хамааралтай юм.

Эдийн засгийн хэт өсөлт ↔ Юаний ханшны асуудал ↔ Үнийн өсөлт

Эдгээр 3 асуудал бие биеээсээ харилцан хамааралтай цогц бөгөөд эдгээрийг шийдвэрлэхийн тулд өөр олон асуудлыг хамруулан авч үзэх, улмаар цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай юм.

Эдгээр асуудлаас улбаалан Хятад улсаас АНУ, Европын холбоо, Япон улстай харилцах улс төр, эдийн засгийн харилцаанд маргаантай, бэрхшээлтэй асуудлууд мөн үүсээд байгаа юм.

1. Эдийн засгийн хэт өсөлт

Хятад улсад газрын тос, үр тариа, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ, хөрөнгө оруулалтын хэмжээ маш их нэмэгдсэнээр орон сууц, барилга байгууламж, тоног төхөөрөмж, бордоо зэргийн үнийг хөөрөгдөж газар, хөрөнгө, зээл, ажиллах хүчний хэрэгцээг нэмэгдүүлсэн.

Зах зээлийн зарчмаар хэрэв газар, зээл, ажиллах хүчний зардал нэмэгдэж байвал тухайн хөрөнгө оруулалт хийгдэхгүй байх ёстой. Гэтэл Хятадад газар болон санхүүгийн хөрөнгийн хувьд зах зээлийн бус засгийн газраас хамаарсан зохицуулалт байдаг учраас хэдийгээр газар

олдохгүй байсан ч энэ зохицуулалтын хүрээнд засгийн газраас тариалангийн газрыг чөлөөлж барилга барих газрыг тухайн орон нутгийн засаг захиргааны мэдэлд эсвэл гадаадын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор тэдэнд хямд үнээр олгодог. Үүний зэрэгцээ зарим орон нутгийн захиргаа газраа үл хөдлөх барилгын компаниудад маш өндөр үнээр худалддаг байна. Хятадын орон нутгийн төсвийн орлогын томоохон хэсгийг үйлдвэрлэлийн НӨАТ бүрдүүлдэг бөгөөд газрын татварын дийлэнхи хэсэг нь орон нутгийн төсөвт үлддэг учраас тухайн мужийн захиргаа өөрийн мэдлийн газраас худалдах, уг газарт үл хөдлөх хөрөнгийн төсөл хэрэгжүүлэх сонирхолтой байдаг байна.² Үүний улмаас газрын үнэ асар ихээр нэмэгдсэн ч гэсэн тариалангийн газрыг багасгах замаар газрыг чөлөөлөн шинэ барилгууд баригдсаар байна.

Хүүгийн түвшинг Засгийн газраас тогтоож хянадаг учраас хүүгийн хэмжээ зах зээлийн эрэлт хэрэгцээгээр зохицуулагдан нэмэгддэггүй байна. Өнгөрсөн 2004 оны дундуур гэхэд хэрэглээний үнийн түвшин нэмэгдсэнтэй холбоотойгоор хадгаламжийн бодит хүү хасах утгатай болж байсан. Энэ байдал нь хувь хүмүүс болон компаниуд хуримтлалаа томоохон барилгын төслүүдийн хөрөнгө оруулалтад оруулах болсон.

Эдийн засгийн өсөлтийг тогтвортой хэмжээнд хуртгал бууруулах чиглэлд ямар арга хэмжээ авч байна вэ?

Хятад улсын Засгийн газраас эдийн засгийн хэт өсөлт, юаний ханшны асуудал, инфляцийг бууруулах асуудлыг цогцоор нь авч үзэж байгаа бөгөөд үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтыг хумих бодлого баримтлан юаний ханшийг тогтвортой байлгаснаар инфляцийг бууруулах бодлого баримтлаж байна.

Хятад улс эдийн засгийн хэт хурдан өсөлт болон инфляцийн огцом өсөлтийг тогтоон барих зорилгоор 2004 оны 11 дүгээр сард нэг жилийн хугацаатай зээлийн хүүгээ 0,27 пунктээр нэмэгдүүлж 5,58 хувь болгосон. Эдийн засгийн дотоод орчныг зохицуулах чиглэлээр 2004 онд олон төрлийн захиргааны арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ч төдийлөн үр дүнд хүрээгүй учраас эдийн засгийг захиргааны арга хэрэгслээр бус зах зээлийн арга хэрэгслээр зохицуулах нь зүйтэй юм байна гэдэгтэй Хятадын эрх баригчид санал нийлэх боллоо. Инфляцийн өсөлтөөс шалтгаалан хадгаламжийн бодит хүү хасах утгатай болж, банкны системээс гадуур мөнгө эргэх болсон нь хүүгийн хэмжээг нэмэгдүүлэхэд хүргэсэн бас нэгэн шалтгаан юм. Хүүгийн хэмжээг нэмэгдүүлсэн нь юаний ханшийг хэт доогуур түвшинд барьж, Хятадын экспортлогч нарт зохиомол давуу тал үүсгэж буй бодлогыг сулруулах чиглэлд хийж буй нэгэн алхам болсон гэж АНУ-ын эрх баригчид үзэж байна.

2. Юаний ханшны асуудал

Хятад улс 1995 оноос эхлэн юаний ханшийг ам.доллартай харьцуулсан тогтмол ханшны бодлогыг хэрэгжүүлж ирсэн.

АНУ-ын 2004 хийсэн гадаад худалдааны тэнцэл 412 тэрбум ам.долларын алдагдалтай гарснаас 161 тэрбум доллар нь Хятадтай хийж буй худалдааны алдагдлаас шалтгаалсан байна гэж АНУ-ын Худалдааны яамнаас мэдээлсэн байна.³ Хятад улс ДХБ-д элссэнээс хойшхи 3 жилийн хугацаанд АНУ-аас Хятадад хийсэн экспорт 80 гаруй хувиар нэмэгдсэн хэдий ч АНУ-ын Хятадтай хийж буй худалдааны алдагдал жил бүр 29 орчим хувиар нэмэгдсэн. Хятад улс өөрийн валютын ханшийг хямд үнэлж ирсний улмаас АНУ-ын оёдол нэхмэл, автомашины эданги, тавилгын зэрэг олон салбарын ажиллагсадыг ажилгүй болоход хүргэсэн. Хятадын хямд үнэтэй экспортын өсөлтөөс шалтгаалан АНУ-ын үйлдвэрлэлийн салбар өнгөрсөн 5 жилийн хугацаанд нийт 3 сая ажлын байраа цомхотгосон байна. Хятад улс юаний ханшаа 40 орчим хувиар доогуур үнэлсэн ханшны бодлого хэрэгжүүлж байгаагийн улмаас Хятадын барааг АНУ-д хямдаар, АНУ-ын барааг Хятадад өндөр үнээр борлуулах нөхцлийг бүрдүүлж байна гэж АНУ-ын үйлдвэрлэгчид үзэж байна.⁴

Юаний хатуу ханшны бодлого яагаад АНУ-ын худалдааны алдагдалыг нэмэгдүүлж байна вэ?

Юаний ам.доллартай харьцах ханш бодит утгаараа чангарсаар байхад ханшийг тогтмол барьснаар Хятадаас АНУ руу экспортлох бүтээгдэхүүний үнэ хямд тогтоогдох боломжийг бүрдүүлж байна. Гэвч АНУ-ын худалдааны алдагдал зөвхөн юаний ханшаас хамааран нэмэгдэж байгаа гэсэн дүгнэлт нь өрөөсгөл юм. Хятадын экспорт хямд байснаар АНУ-ын импорт нэмэгдэж, Хятадын хямд бүтээгдэхүүн АНУ-ын зах зээлд орж ирсний улмаас АНУ-ын өндөр өртөгтэй дотоодын үйлдвэрлэгч нарын ижил бүтээгдэхүүний борлуулалт багасч АНУ-ын экспорт буурна. Ханшийг тогтмол барьснаар АНУ-ын Хятад руу хийж буй экспортын барааны үнэ өндрөөр үнэлэгдэх учир экспортын хэмжээ нэмэгдэх боломжийг багасгаж байна. Үүний дүнд АНУ-ын худалдааны алдагдал нэмэгдэж байна.

Хэрэв Хятад улс юаний ханшаа чангаруулбал экспортын барааны ам.доллараар илэрхийлэгдсэн үнэлгээ нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл одоо 1 ам.доллар 8.3 юанитай тэнцүү байхад худалдаж байсан барааны үнэ 1 ам.доллар 7.2 юаньтай тэнцэх ханштай үед 5-6 хувиар нэмэгдэн үнэлэгдэж АНУ-д экспортлогдох шаардлагатай болно.

Хятад улсын юаний ханш чангарна гэсэн хүлээлт 2004 оны эцэст

дэлхийн валютын зах зээл дээр тархаж, олон улсын валютын арилжааныхан их хэмжээний ам.доллар Хятадад оруулж ирсэний улмаас Хятад улсын гадаад валютын нөөц 2004 оны 4 дүгээр улиралд 95.4 тэрбум ам.доллараар нэмэгдсэн. Олон улсын валютын арилжаа эрхлэгчид юаний ханш чангарах сургаар 100 орчим тэрбум ам.долларыг Хятадад оруулан үл хөдлөх хөрөнгийн салбарт хөрөнгө оруулах болсон. Мөн энэ сургаар Хятадын дотоодын компаниуд болон иргэд долларын хадгаламжаа юань руу шилжүүлэх болсон зэрэг нь зах зээлд валютын дамын худалдааг /спекуляцийн/ улам хөөрөгдөх болсон. Гадаадын валютын спекуляци хийх зорилготой наймаачид худалдан авсан үл хөдлөх хөрөнгөө юаний ханшийг чангарахаар буцаан зарж ашиг олохоор хүлээж байгаа юм.

Харин 2005 оны эхний улирлын дүнгээр Хятад улсын гадаад валютын нөөц 49.2 тэрбум ам.доллараар нэмэгдсэн нь өмнөх үетэй харьцуулахад бараг 2 дахин буурсан үзүүлэлт юм. Энэ нь Хятадын эрх баригчид юаний ханшийг ам.доллартай уялдуулан тогтвортой барих бодлогоо ойрын үед өөрчлөх бодолгүй байгаагаа 2005 он гарснаас хойш дээд түвшинд удаа дараа хийсэн мэдэгдлүүд нь спекуляцын хөөрөгдлийг бага зэрэг намжаасны илрэл юм.

Хөрөнгө оруулалтын Lehman Brothers банкнаас 2005 оны 4 дүгээр сард гаргасан тайланд “Хятад улс гадаад валютын нөөцийн багц дахь ам.долларын хувь хэмжээг багасгасан бөгөөд ингэснээр АНУ өсөн нэмэгдэж буй төлбөрийн тэнцлийн алдагдлаа санхүүжүүлэх (*АНУ-ын Засгийн газрын өрийн бичиг*) тал дээр Азийн орнуудад найдах боломжгүй боллоо” гэж дурджээ. Хятад улс дэлхий дээр гадаад валютын нөөцөөрөө Япон улсын дараа хоёрдугаарт бичигддэг бөгөөд 2004 оны эцсийн байдлаар 610 тэрбум ам.доллар (470 тэрбум евро)-т хүрч өнгөрсөн оныхоос 209.9 тэрбум ам.доллараар (161.5 тэрбум евро) өссөн нь тус улсын гадаад худалдааны тэнцэл ихээхэн ашигтай гарч байгаатай холбоотой юм.

Хэдийгээр гадаад валютын нөөц өссөн ч Хятадын Төв банк дахь ам.долларын активын хэмжээ 2003 онд 82 хувь байсан бол 2004 онд 76 хувь болж буурсан байна. Үүнээс үзэхэд тус улс гадаад валютын нөөцөө аажмаар ам.доллараас өөр валют руу шилжүүлэх диверсификаци хийж байна. Хятад улс өөрийн гадаад валютын нөөцийн бүтцээ албан ёсоор мэдээлдэггүй боловч түүний ихэнхи хэсгийг АНУ-ын Засгийн газрын өрийн бичиг, ам.доллар эзэлдэг байна. Япон улсын Ерөнхий сайд Жуничиро Койзуми болон Өмнөд Солонгосын албаны

хүмүүс мөн өөрсдийн гадаад валютын нөөцийг ам.долларт үндэслэсэн байгааг өөрчлөн диверсификаци хийхээр төлөвлөж байгаагаа мэдэгдсэн. Эдгээр мэдэгдэл болон Хятад улсын авч явуулж буй алхамаас дүгнэхэд АНУ өөрийн улсын өсөн нэмэгдэж буй төлбөрийн тэнцлийн алдагдлыг Азийн орнуудын албан ёсны санхүүжилтээс санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал болох юм. Хятад улс ойрын хугацаанд валютын ханшны түр зуурын өөрчлөлтийг даган өөрийн гадаад валютын нөөцийн бүтцээ өөрчлөх бодолгүй байгаагаа удаа дараа мэдэгдэж байсан.

Хятадын Засгийн газраас гадаад хөрөнгө оруулалтын хэмжээг бууруулах, мөн дотоодын компаниудад төвлөрөөд байгаа ихээхэн хэмжээний гадаад валютын орлого болон хуримтлалыг гадаадад хөрөнгө оруулалт хийхийг урамшуулах бодлого баримтласан нь валютын ханшны спекуляцыг бууруулахад нөлөөлсөн. Хятад улсын гадаад валютын нөөц 2005 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар 659 тэрбум ам.доллар (www.pbc.gov.cn) байна. Хятад улсын Засгийн газраас гадаадад хөрөнгөө гаргах үйл явцыг улам дэмжиж, валютын ханшны спекуляцаас ашиг олох зорилгоор орж ирэх хөрөнгийн урсгалыг хаах замаар юаний ханшны чангарах үйл явцыг саармагжуулах арга хэмжээ авсаар байна.

Хятад улсын гадаад худалдааны ашиг 2005 оны эхний улиралд 16.6 тэрбум ам.доллар, гадаадын шууд хөрөнгө оруулалт 13.4 тэрбум ам.доллар байсан. Гэтэл гадаад валютын нөөцийн хэмжээ энэ хоёр үзүүлэлтийн нийлбэрээс 19 тэрбум ам.доллараар илүү нэмэгдсэн нь валютын ханшны спекуляци хийх зорилготой мөнгөн хөрөнгө бусад хэлбэрээр орж ирсээр байгааг илтгэж байна. 2004 оны 4 дүгээр улирлын дүнгээр энэхүү тооцоонд ороогүй өсөлт 55 тэрбум ам.долларын хэмжээтэй байсан.

АНУ зэрэг Хятад улсын худалдааны томоохон түнш улсууд Хятад улс юаний ханшийг хөдөлгөөнгүй хатуу барьж, өөрийн улсын экспортлогч нартаа шударга бус давуу тал олгож буйг шүүмжлэн, юаний ханшийг уян хатан болгохыг сүүлийн хоёр жилийн турш шаардсаар байгаа ч Хятад улс санхүүгийн салбараа эрүүлжүүлж, эдийн засгаа илүү тогтвортой болгосны дараа валютын ханшны бодлогоо өөрчлөх болно гэж мэдэгдэж байна.

АНУ-ын Сангийн сайд Жон Сноу 2005 оны 3 дугаар сарын 29-ны өдөр Хятад улсын Гадаад валютын зохицуулах хорооны шинэ дарга Ху Сяолиэнд валютын ханшны тал дээр цаашид хамтран ажиллах талаар захидал илгээсэн байна. Үүний дараахан Хятадын Сангийн сайд Зин Рэнчин, Төв Банкны Ерөнхийлөгч Жоу Сяочуань нар 2005 оны 4 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд болсон ОУВСан болон Дэлхийн Банкны “Хаврын

чуулган” болон 2005 оны 4 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд хуралдах “Их Долоо”-ын уулзалтад оролцожгүй болсноо албан бичгээр мэдэгджээ.

Хятадын тал дээрх хуралдаануудад оролцожгүйгээ мэдэгдсэн нь АНУ болон “Их долоо”-гийн зүгээс юаний ханшийг уян хатан болгох чиглэлээр хоёр жилийн турш явуулж буй хүчин чармайлт үр дүнд хүрээгүйг харуулж байгаа бөгөөд одоо үүнээс өөр хатуу хэлбэрээр шаардах нь зүйтэй гэж шинжээчид дүгнэж байна.

АНУ-ын Сенат Хятад улс юаний ханшаа уян хатан болгож чөлөөлөх хүртэл Хятадын бүх төрлийн импортын бараанд 27.5 хувийн татвар тогтоохоор бэлтгэж байна. АНУ-ын Хятад улстай хийж буй гадаад худалдааны алдагдал 2004 онд 162 тэрбум ам.долларт хүрч өссөн бол 2005 оны 2 дугаар сарын дүнгээр 61 тэрбум ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеээс 47 хувиар өссөн байна.

Хятад улс юаний ханшийг хөдөлгөөнгүй хатуу барьж байгаа нь АНУ-ын худалдааны алдагдал асар ихээр нэмэгдүүлж байгаа бөгөөд улмаар “Их долоо”-гийн орнуудын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх болсон байна.

“Их Долоо”-гийн дипломат шахалт: Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд АНУ-ын Төрийн Сангийн сайд Жон Сноу, Английн Сангийн сайд Гордон Браун, Германы Сангийн сайд Ханс Эйчел болон “Их долоо”-гийн бусад сайд нар Хятад улсыг юаний ханшаа яаралтай чөлөөлөхийг аядуу аргаар шаардсаар ирсэн. Хятад улс хэдийгээр “Их Долоо”-гийн гишүүн биш ч сүүлийн хоёр жилийн уулзалтад Сайд нараа ажиглагчаар оролцуулж ирсэн.

Бушийн Засгийн газар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр сайд Сноуг Хятадад албан ёсоор томилон ажиллуулсан ч үр дүнд хүрээгүй. Гэсэн хэдий ч АНУ-ын Төрийн Сангаас гаргадаг “валютын ханшаар манипуляци хийдэг орнууд”-ын жагсаалтад Хятад улсыг оруулалгүй явсаар өдийг хүрчээ.

Юаний ханшны асуудал нь оёмол, нэхмэл бүтээгдэхүүний асуудалтай шууд холбоотой тул Хятадын талын энэхүү байр суурийн хариуд АНУ, Европын Холбооны хууль тогтоогчид болон үйлдвэрлэгчид Хятадын оёмол, нэхмэл бүтээгдэхүүний импорт хэт их нэмэгдэж дотоодын зах зээлийг гажуудалд хүргэж байна гэсэн үндэслэлээр ДХБ-ын хэмжээнд ярилцан Хятадын оёмол, нэхмэл бүтээгдэхүүний импортод татвар тогтоохоор бэлтгэж байна.

“Lehman Brothers Holdings” компаний төсөөлж байгаагаар Хятад улс 2005 оны 6 дугаар сарын эцсээр юаний ханшийг ам.доллар, евро,

иен, воны зэрэг валютын багцын ханштай уялдаатайгаар тогтоох бөгөөд 2005 оны эцэс гэхэд ам.доллартай харьцах юаний ханш 7.9 болж чангарах төлөвтэй байна.

Хятадын Төв банкны мэдээгээр 2005 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр юаний ам.доллартай харьцах ханш маш бага хэмжээгээр чангарч 8.2700 болсон байна.⁵

Юаний ханшны бодлого Европын холбоонд сөрөг нөлөө үзүүлэх боллоо

Өнөөг хүртэл юаний ханшны асуудал АНУ, Хятад хоёрын хооронд идэвхитэй яригдаж байсан бол одоо энэ асуудал хальж Европын Холбооны улсуудад сөргөөр нөлөөлж эхэллээ. Хятадын Засгийн газраас 2005 оны 4 дүгээр сар 11-ний өдөр гаргасан мэдээллээс үзэхэд Хятад улсын экспорт 2005 оны эхний 3 сард 33 хувиар нэмэгдсэн байна.

Европын холбоонд багтдаг 12 орны нийт ДНБ-ны 20 хувийг экспортын орлогоор бүрдүүлдэг учраас Хятадын импортын энэхүү өсөлт нь тэдгээр орнуудын эдийн засагт сөргөөр нөлөөлөх нь ойлгомжтой. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд евротой харьцах ам.долларын ханш, улмаар юаний албан ханш 32 хувиар буурсан нь Европд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг улам илүү үнэтэй болгож, улмаар өрсөлдөх чадваргүй болгож байна.

Хятадын импортын хэт өсөлттэй холбоотойгоор Европын Холбооны Худалдааны Комиссар Питер Манделсон 2005 оны 3 дугаар сарын 9-ны өдөр хийсэн мэдэгдэлдээ “Квотыг алга болгосны дараа Хятадын Засгийн газраас зөвхөн 2005 оны эхний хоёр сарын дотор үүнээс урьд өмнө олгож байсантай тэнцэх их хэмжээгээр гадаад худалдааны лиценз олгосон байна. Ийм замбараагүй байдлыг бид зүгээр хараад суухгүй” гэж мэдэгджээ.

Америк долларын ханш: АНУ-ын төсвийн алдагдал нэмэгдэхийн хирээр ам.долларын ханш сүүлийн 3 жилийн турш үргэлжлэн унаж байгаа бөгөөд энэ нь АНУ импортын бараа худалдан авах валют худалдан авахад илүү их хэмжээний доллар шаардлагатай болж байна гэсэн үг юм. Ам.долларын евротой харьцах ханш сүүлийн хоёр сарын хугацаанд аажмаар чангарч байна. Энэ нь АНУ-д ажил эрхлэлт нэмэгдэж буйтай (2005 оны 3 дугаар сараас хойш 274000 шинэ ажлын байр бий болсон байна) холбоотой гэж Bloomberg компаний шинжээчид үзэж байна. Ам.долларын евротой харьцах ханш 2005 оны эцэс гэхэд 1.20-1.25 хооронд хэлбэлзэх төлөвтэй байна гэж “Bank of America” компанийн гадаад валютын газрын дарга Роберт Синчэ мэдэгджээ.⁶

3. Үнийн өсөлт

Хятад улсад хэрэглээний үнийн индекс нэмэгдэж буй нь хэрэглэгчдийн хэрэглээ өсөн нэмэгдсэнээс бус харин үр тариа зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, газрын тосны үнийн өсөлт болон хэт их хөрөнгө оруулалтаас шалтгаалсан юм.

Хятад улс 2005 онд эдийн засгийн бодит өсөлтийг бууруулан 8 хувь, инфляцийг 4 хувьд хүргэхээр төлөвлөжээ. Хятад улсын хэрэглээний үнийн индекс өнгөрсөн оны 7, 8 дугаар саруудад 5.2 хувьд хүрсэн нь сүүлийн 7 жилийн хамгийн өндөр үзүүлэлт юм. Хятадын 2005 оны 1 дүгээр сарын хэрэглээний үнэ өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өссөн байгаа нь өмнөх саруудын дүнгээс буурсан байна. Ийнхүү хэрэглээний үнийн индекс буурсан нь голчлон хүнсний бүтээгдэхүүний үнийн бууралтаас шалтгаалсан юм. Инфляцийн хэмжээ ийнхүү буурсан нь зах зээл дээр цаашид хүүгийн хэмжээ нэмэгдэх байх гэсэн болгоомжлолыг багасгаж өгсөн.

Юаньтай харьцах ам.долларын ханш буурвал газрын тос зэрэг Хятадын импортын барааны ам.доллараар илэрхийлэгдсэн үнэ нь өсөх болно. Үүнтэй холбоотойгоор Хятад улс гаднаас инфляцийг импортлох болно гэж АНУ-ын шинжээчид дүгнэж байна. Тайвань, Солонгос, Япон зэрэг улсууд өөрсдийн үндэсний валютын ам.доллараас хамаарсан хамаарлыг (улмаар юаниас) салгах үйл явц явагдаж эхэлсэн нь тухайн улсууд дээрхи инфляцийн нөлөөллийг импортлон авахаас сэргийлсэн алхамууд юм.⁷

Цахилгааны үнийн өсөлт: 2004 онд нүүрсний үнэ ихээхэн нэмэгдсэнтэй холбоотойгоор 2005 онд орон даяар нэг квт/цаг цахилгааны үнийг 0.01-0.02 юаниар нэмэгдүүлэхээр Хятадын Засгийн газар төлөвлөж байна. Цахилгааны үнийг ийнхүү нэмэгдүүлснээр цахилгааны төлбөр нийт дүнгээрээ 48 тэрбум юаниар нэмэгдэж, улмаар инфляцийг 0.12 хувиар нэмэгдүүлэх юм. Өнгөрсөн онд Зүүн Хятадын нутагт нүүрсний үнэ хамгийн хурдацтай нэмэгдсэн учраас тус бүс нутаг дахь цахилгааны үнэ 0.02 юань (0.0024 цент)-аар өсөхөөр байна. Засгийн газраас төсвийн байгууллага, бордооны аж ахуй болон хөдөө аж ахуйн компаниудыг хамгаалах бодлогын үүднээс тэдний цахилгааны үнийг нэмэхгүй. Энэ удаагийн цахилгааны үнийн өсөлт нь нүүрсний үнийн өсөлтийг цахилгааны үнэтэй шууд уялдаатай холбох Засгийн газрын төлөвлөгөөний хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ юм. Уг төлөвлөгөөний дагуу хэрэв нүүрсний үнэ сүүлийн 6 сард 5-аас илүү хувиар нэмэгдвэл уг үнийн өсөлтийн ачааллын 70 хувийг эцсийн хэрэглэгчид шилжүүлж, үлдэх 30 хувийн ачааллыг өөрсдийн зардалд

тусгах ажээ. Цахилгаан станцуудын зардлын 50 орчим хувийг эзэлдэг нүүрсний үнэ 2004 онд 50 гаруй хувиар нэмэгдсэн байна.

Хятад улсад тулгараад буй эрчим хүчний хүндрэл 2005 онд үргэлжилсээр байх болно. Шинжээчдийн тооцоолсноор Хятад улс 2005 онд нийт 20-25 сая квт/цагийн эрчим хүчний хомсдолтой байхаар байна. “Энэхүү тооцоолол нь 2004 онд бий болсон эрчим хүчний дутагдалтай харьцуулахад бага тоо юм” гэж Хятадын Эрчим хүчний зөвлөлийн ерөнхий нарийн бичгийн дарга Ван Юнган хэллээ. 2005 онд Хятад улсын эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 15.88 хувиар буюу 70 сая квт-аар нэмэгдэж 510.7 сая квт-д хүрэх бөгөөд үүний зэрэгцээ хэрэглээ 13 хувиар нэмэгдэх тооцоотой байна. Хятад улсын эрчим хүч үйлдвэрлэх суурилагдсан тоног төхөөрөмжүүд нүүрс, газрын тос, усны дутагдалтай байдал болон байгалийн, цаг уурын нөлөөллөөс шалтгаалаад тэр бүр бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаагаас эрчим хүчний дутагдал үүсч байгаа ажээ. 2005 онд Хятад улсын хамгийн их үйлдвэржсэн Зүүн Хятадад нийт 11 сая квт-ын эрчим хүчний дутагдал гарахаар байна. Хятад улс 2004 онд нийт 2.17 триллион квт/цаг эрчим хүч хэрэглэсэн байна.

Нүүрсний үнэ: Хятадад 2005 онд коксны үнэ үргэлжлэн нэмэгдэх хандлагатай байна гэж Хойд Хятадын кокс, химийн бүтээгдэхүүний холбооноос гаргасан мэдээлэлд дурджээ. Уг судалгааны мэдээлэлд дурдсанаар 2005 онд Хятад улс 300 сая тонн түүхий ган боловсруулах бөгөөд үүнтэй уялдаж коксын үнэ үргэлжлэн нэмэгдэхээр байна. Коксны үнийг нэмэгдүүлж буй өөр нэгэн шалтгаан бол коксжуулах зардал болон тээвэрлэлтийн зардал нэмэгдэж буй явдал юм. Хятадын Худалдааны яамнаас 2005 онд экспортод гаргах коксын квотыг 2004 оныхтой адил буюу 14 сая тонноор тогтоосон энэ нөхцөлд 1 тонн коксын экспортын үнэ 250 орчим ам.доллар байхаар байна. Хятадын Гаалийн газраас гаргасан мэдээллээс үзэхэд өнгөрсөн оны эхний 11 сард Хятад улс 13.6 сая тонн кокс экспортлосон нь өмнөх жилийн тухайн үеэс 0.6% доогуур байсан байна. Хятад улс 2004 оны 11 дүгээр сард 16.4 сая тонн кокс үйлдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.4% нэмэгдсэн байна. Хятад улсын 2004 оны коксын үйлдвэрлэл 176 сая тоннд хүрсэн нь өмнөх оныхоос 26.2% нэмэгдсэн байна. Хятад улсад төмөр, гангийн үйлдвэрлэл ихээхэн хурдацтай өсч буйгаас коксын хэрэгцээ өсч, үнэ нь нэмэгдсээр байна. Хятадын Зүүн хэсэгт 1 тонн коксын үнэ 1350-1400 юань, Төв Хятадын Шаньси мужид 1150-1180 юань, Хойд Хятадын Хэбэй мужид 1150-1200 юань орчим үнэтэй байна.

Нефтийн үнэ: 2020 он гэхэд Хятад улсын нефтийн хэрэгцээ 400 сая тонн хүрэх хандлагатай байна. Хятад улс дотооддоо 160-170 сая тонн түүхий нефть боловсруулах боломжтой ажээ. Эрчим хүчний үр ашиг багатай хэрэглээ нь Хятад улсыг нефтиэс хараат улс болоход голчлон нөлөөлсөн гэж мэргэжилтнүүд үзэж байна. Хятадын Стандартын ерөнхий газраас хийсэн судалгаагаар Хятад улсын нийт нефтийн импортын 30 хувийг суудлын автомашинууд хэрэглэдэг ажээ. Хятадад үйлдвэрлэсэн суудлын автомашин, автобус болон ачааны машинууд 100 км-т зарцуулах түлшний зарцуулалтаараа Европд үйлдвэрлэсэн машинтай харьцуулахад 25 хувиар, Японтой харьцуулахад 20 хувиар, Америктай харьцуулахад 10 хувиар тус тус илүү байдаг байна. Үүнтэй холбоотойгоор Хятад улс түлшний үр ашигтай зарцуулалтын стандартыг батлан гаргаж мөрдүүлж байна. 2005 оны 7 сараас эхлэн мөрдөх энэхүү стандарт хэрэгжсэнээр Хятад дахь түлшний хэрэглээ 2009 он гэхэд 15 хувиар буурахаар тооцсон байна.

Хятадын газрын тосны томоохон компаниуд 2004 онд нийт 850 мянган тонн газрын тосны ордыг хайж илрүүлсэн байна. Хятад улсын газрын тосны хэрэглээ 2004 онд 288 сая тонн байсан бол 2005 онд 320 саяд хүрч, 11 хувиар өсөхөөр төлөвлөгдсөн байна.⁸

Дүгнэлт, санал

Манай улсын худалдааны хамгийн том түнш, хамгийн том гадаадын хөрөнгө оруулалт хийсэн улс болох Хятад улсын эдийн засагт тулгараад буй дээрх асуудлуудын учир шалтгааныг тодруулан судлах нь манай улсын эдийн засаг, үйлдвэрлэлийг уялдуулан хөгжүүлэх, цаашдын хандлагыг тодорхойлон төлөвлөхөд тустай юм.

1. Хятад улсын оёмол, нэхмэл бүтээгдэхүүний экспортод АНУ, Европын холбоо татвар ногдуулбал Хятадын зарим оёмол, нэхмэлийн үйлдвэрүүд Монгол Улс руу үйлдвэрлэлээ шилжүүлж болох юм. Квот цуцалснаас хойш өнөөг хүртэл Хятад улсын оёмол нэхмэл бүтээгдэхүүний экспортын эргэн тойронд өрнөсөн үйл явцаас ажиглахад цаашид Хятадын хямд үнэтэй бүтээгдэхүүний дампингийн эсрэг АНУ, Европын Холбоо зэрэг улсууд төрөл бүрийн хориг тавих нь тодорхой болж байна. Тиймээс манай улс терроризмын эсрэг үйл явцад оруулж буй хувь нэмэр оролцоо зэрэг арга хэрэгслийг ашиглан АНУ, Европын Холбооноос (GSP) гадаад худалдааны хөнгөлөлттэй тарифын болон бусад таатай нөхцөл олж авах талаар ажиллах хэрэгтэй болов уу.

2. Манай улс дахь гадаадын хөрөнгө оруулагч татварын хөнгөлөлтөд хамрагдаж буй хугацаа нь дуусахаас өмнө үйлдвэрлэлээ

буцаан гаргах, эсвэл өөр улс руу шилжүүлэх тохиолдолд тухайн хугацаанд чөлөөлөгдсөн, хөнгөлөгдсөн татвараа улсад буцаан төлөх ёстой боловч үүнийг хэрхэн буцаан төлүүлэх арга, хэлбэрийг тодорхой журамлаагүй байна. Энэ байдлыг 2004 оны 4 дүгээр улиралд Хятадын олон тооны оёмол, нэхмэлийн салбарын олон хөрөнгө оруулагчид манай улсад явуулж байсан үйлдвэрээ буцаан гаргасан боловч чөлөөлөгдсөн татвараа бидэнд буцаан төлөөгүй байгаа жишээнээс тодорхой харж болно. Энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ авах саналтай байна.

3. Хятад улс зэс, төмөр, цемент, нүүрс, цайр, хөнгөн цагаан, вольфрам зэрэг олон төрлийн ашигт малтмалын хомсдолд ороод байна. Дунд хугацаанд Хятад улс эдгээр ашигт малтмалуудыг гадаад, дотоодоос найдвартай хангах эх үүсвэрийг баталгаажуулах чиглэлээр ихээхэн анхаарч, зээл, хөрөнгө оруулалтын нэн тааламжтай нөхцлүүдийг олгож, дэмжих бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Энэ арга хэмжээний хүрээнд Хятад улс хөрш зэргэлдээ болон бусад гадаад орноос ашигт малтмал импортлох үйл явц эрчимжиж байна. Жишээлбэл Хятад улс Австрали, Бразил, Чили болон Африкийн улсуудтай төрөл бүрийн ашигт малтмалын орд газрыг хамтран ашиглах төслүүдийг эхлүүлээд байна. Энэхүү эрэлт, хэрэгцээний далайцыг Хятадын болон бусад гадаадын олон компаниуд ихээхэн анзаарч, Хятадтай хил залгаа улс, орнууд дахь ашигт малтмалын ордуудыг хамтарч ашиглан, Хятад улсад нийлүүлэх хамтын ажиллагааг хөгжүүлэх боллоо. Манай улс ашигт малтмалын тухай хуулийн төслийг боловсруулж батлан гаргасан тэр үед буюу 1998 оны үед дэлхийн ашигт малтмалын зах зээлийн эрэлт нийлүүлэлт, нөхцөл, үнэ зэрэг нь одоотой харьцуулахад нэлээд ялгаатай байсан. Өөрөөр хэлбэл тухайн үед манай уул уурхайн салбарт хөрөнгө оруулах сонирхолтой гадаадын хөрөнгө оруулагч маш цөөн байснаас тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчдад 1) Орлогын албан татвараас эхний 10 жил чөлөөлж, дараагийн 10 жил 50 хувь хөнгөлөх 2) Дүрмийн санд орох технологийн зориулалттай тоног төхөөрөмжийг импортын татвараас чөлөөлөх 3) Тогтвортой байдлын гэрээ байгуулах зэрэг татварын хөнгөлөлт олгохоор хуульчилсан. Манай улсын уул уурхайн салбарт хөрөнгө оруулахыг сонирхогчдын тоо ихэссээр буй энэ нөхцөл байдалд нийцүүлэн бид уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой татварын зарим хөнгөлөлттөө багасгах саналтай байна. Гадаад орнууд зах зээлийн нөхцөл өөрчлөгдсөн үед худалдааны бодлого, бүтээгдэхүүний үнийг зах зээлийн эрэлт, үнийн өсөлттэй холбогдуулан цаг тухайд нь хэрхэн өөрчилдөг болохыг дараах жишээнээс харж болно.

Хятадад “зах зээлийн статус” олгосон цөөхөн орнуудын нэг нь Австрали юм. Хятад улс бол Австралийн гадаад худалдааны гурав дахь том түнш бөгөөд хоёр дахь томоохон экспортын зах зээл юм. 2004 онд хоёр орны худалдааны эргэлт 21.3 тэрбум ам.долларт хүрчээ. Австралийн төмрийн хүдрийн хамгийн том импортлогч 2004 оноос өмнө Япон улс байсан бол 2004 оноос эхлэн Хятад улс Австралийн төмрийн хүдрийн хамгийн том импортлогч болсон.

Саяхан 2005 оны 3 дугаар сарын эцсээр Австрали улс Хятадад экспортлодог төмрийн хүдрийн үнээ 71.5 хувиар нэмэгдүүлэх болсон нь хоёр орны хооронд ихээхэн маргаантай асуудлын нэг болоод байгаа.

Австрали улсаас импортлодог төмрийн хүдэр болон эрчим хүчний цаашид гарч болох үнийн огцом өсөлтөөс сэргийлэх, улмаар ирээдүйд Австралийн ашигт малтмалыг импортлох өрсөлдөгчид гарч ирэх замыг хаах зорилгын үүднээс Хятад улс Австрали улстай ойрын хугацаанд чөлөөт худалдааны гэрээ байгуулах сонирхолтой байгаа талаар Хятад улсын Худалдааны орлогч Сайд Ма Сьюхунг мэдэгдсэн байна.

Австрали улсын Ерөнхий сайд Жон Ховардын 2005 оны 4 дүгээр сарын 18-аас эхлэн Хятад улсад хоёр хоногийн хугацаатай хийсэн айлчлалын гол зорилго нь энэхүү чөлөөт худалдааны гэрээний асуудал юм. Хятад улсад “зах зээлийн статус” олгосоны төлөө Жон Ховард нутаг нэгтнүүдээсээ ихээхэн зэмлэл хүртэж байгаа. /Синхуа агентлаг/

4. Аж үйлдвэрийн чиглэлээр ялангуяа уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг тогтвортой хөгжүүлэх. Өөрөөр хэлбэл, зөвхөн Хятад улсын өнөөгийн хэрэгцээг хангах, валютын орлогоо нэмэгдүүлэх зорилгоор нэгэн төрлийн ашигт малтмал олборлох уурхайг олноор нь нэг дор нээн ашиглахаас зайлсхийх, хэдийгээр ашиглалтын лиценз нь хувь болон хуулийн этгээдийн мэдэлд байдаг хэдий ч уул уурхайг тогтвортой хөгжүүлэх Засгийн газрын бодлогод нийцүүлэн тухайн орд газрыг ашиглах, олборлолт, баяжуулалт, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мөн технологийн сонголт хийхэд улсын зүгээс зохицуулалт хийдэг байх нь зүйтэй. Хятад улс хэдийгээр урт хугацааны бодлого стратегитэй байсан хэдий ч тухайн бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт, хэрэгцээ ихээр нэмэгдэж, улмаар үнэ нь огцом өсч буй бол орон нутгийн засаг захиргаа, томоохон хөрөнгө оруулагчид уг бодлого стратегийг үл харгалзан төмөрлөг, автомашин, ноолуурын үйлдвэр, цементийн үйлдвэр, нүүрсний олон тооны жижиг үйлдвэр зэргийг зөвхөн тухайн үеийн эрэлт, хэрэгцээг хангах, орлогоо нэмэгдүүлэх зорилгоор хэт олноор нь байгуулсан учраас Хятад улсад өнөөгийн бүтцийн шинжтэй хүндрэлтэй асуудлууд үүссэн бөгөөд Хятадын эрх баригчид үүнийг “үйлдвэрлэлийн салбаруудыг

уялдаатайгаар хөгжүүлээгүй”, “тогтвортой бус хөгжил”, “ирээдүйд чиглээгүй харалган хөгжил” зэргээр нэрлэн томъёолж байна. Хятад улсад тулгараад буй энэхүү бүтцийн гажуудал нь тус улсын өнөөгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд ихээхэн хүндрэл, бэрхшээл учруулж байна. Манай улс жижиг улс, Хятад улсын хэрэгцээ асар их, тиймээс манай улс уул уурхайн салбараа уялдаатайгаар тогтвортой хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг чанд мөрдүүлэх нь зүйтэй.

5. Хятад улс өнгөрсөн 10 жилд аж үйлдвэржүүлэх эрчимтэй бодлого баримтласны дүнд аж үйлдвэрийн цэгцтэй бодлого алдагдаж улмаар төмөрлөг, цемент, нүүрс, ноолуурын зэрэг олон тооны үйлдвэрүүд байгуулагдаж, үйлдвэрлэлийн хүчин чадлын илүүдэл бий болгосон. Энэхүү үйлдвэрлэлийн хүчин чадал хэт өргөжснөөр Хятадын эдийн засагт олон хүндрэл бэрхшээлтэй асуудлууд бий болсон. Үүнийг хянан үзсэний дүнд Хятад улс үйлдвэрлэлийн салбаруудаа уялдаатайгаар тогтвортой хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх болсон бөгөөд энэ арга хэмжээний хүрээнд жижиг хэмжээтэй үйлдвэрүүд болон нэг дор олноор төвлөрсөн үйлдвэрүүд, үр ашиг муутай үйлдвэрүүд, энгийн буюу технологи муутай мянга мянган үйлдвэрүүдийг хааж, үлдсэн томоохон үйлдвэрүүдэд дэлхийн шилдэг технологийг үе шаттайгаар нэвтрүүлэх замаар технологийн шинэчлэл хийж байна. Эдгээр хаагдсан үйлдвэрүүдийн үр ашиг муутай хоцрогдсон технологитой үйлдвэрлэлийн хуучин тоног, төхөөрөмж, дамжлага манай улс руу экспортоор орж ирэх магадлал маш их байна. Хятадын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд асан Жу Рунжи “...техник, технологийг шинэчлэх болно. Гэхдээ хээнэг нь дураар дургихгүй. Нэгдсэн бодлогоор зохицуулна. Эс тэгвэл манай улс хөгжингүй орнуудын хоцрогдсон технологийн хогийн сав болно” гэж хэлж байсан. Иймд технологийн сонголтыг зөв хийх нь манай улсын анхаарвал зохих асуудал юм.

6. Хятад улсад хүүгийн түвшинг Засгийн газраас тогтоож хянадаг бөгөөд одоогоор тус улсын хүүгийн дээд хязгаар нь манай санхүүгийн зах зээл дээрх хүүгийн түвшнээс маш доогуур байгаа энэ нөхцөлд манай улсад Хятадын арилжааны банкны салбараа нээн банкны үйл ажиллагаа явуулбал манай улсын санхүүгийн зах зээл дээрхи зээлийн хүүгийн түвшинг тодорхой хэмжээгээр бууруулах боломжтой болно. Хятадад хувийн банкууд олноор байгуулагдаж байгаа бөгөөд тус улс ДХБ-д элсэхдээ авсан амлалтын дагуу банкны салбар дахь хязгаарлалтуудаа багасгаж байгаа бөгөөд 2007 гэхэд ямар нэгэн хязгаарлалтгүй болсон байх ёстой.

7. Хятад, Япон, Өмнөд Солонгос, Малайз, Тайланд улсууд гадаад валютын нөөцийн багц дахь ам.долларын хувь хэмжээг бууруулан аажмаар олон валютын багцтай болох хандлагатай байна. Олон улсын

санхүүгийн шинжээчид энэ үйл явцыг сүүлийн 3 жилийн турш ам.долларын ханш тогтвортой буурах хандлагатай байгаатай холбон тайлбарлаж байна. Манай улсын гадаад валютын нөөцийн багцад ам.долларын эзлэх хувийн жинг зохих түвшинд байгаа эсэхийг авч үзэх шаардлагатай.

8. Хятад улсад цахилгааны үнэ цахилгаан үйлдвэрлэж буй арга хэлбэр, эх үүсвэр, хэрэглэгчдийн төрөл, засгийн газрын хөгжлийн бодлого зэргээс шалтгаалан бүс нутаг бүртээ ялгавартай тогтоогддог байна. Хятад улсад үүсээд буй цахилгааны хомсдол бүтцийн гажуудлаас улбаатай учраас зарим муж цахилгааны хомсдолтой байхад зарим мужид хомсдолгүй байна. Хятадын Засгийн газраас нүүрсний үнийн өсөлтийг цахилгааны үнэтэй шууд уялдаатай холбох чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь нүүрсний үнийн өсөлтөөс эцсийн хэрэглэгчдэд үүсэх ачааллыг бууруулах, эрчим хүчний түгээлт, хуваарьлалтад тавих хяналтыг сайжруулах зэрэг олон давуу талтай арга хэмжээ болсон байгаа тул энэ схемийг манай улсад ашиглах боломжийг судлах саналтай байна. Хятад улсад үүсээд буй нүүрсний хомсдол нь мөн л бүтцийн гажуудлын шинж чанартай юм. Өөрөөр хэлбэл Хятад улсад одоогоор үүсээд буй нүүрсний хомсдол нь голчлон коксжсон нүүрсстэй холбоотой үүсч байна.

9. Түлшний хүрэн нүүрсний эрэлт, хэрэглээ өсөн нэмэгдэж буй хэдий ч Хятад улс одоогоор өөрийн түлшний хүрэн нүүрсний хэрэгцээг бүрэн хангах нөөц болон үйлдвэрлэлийн хүчин чадалтай байна. Түлшний хүрэн нүүрсстэй холбоотой үүсч буй зангилаа асуудал нь үнийн өсөлт, төмөр замын тээврийн саатал, хүлээлт юм. Хятадын хойд бүс нутаг дахь түлшний хүрэн нүүрсний дундаж үнэ манай улсын хүрэн нүүрсний дундаж үнээс 3-5 дахин өндөр (1 тонн 300 орчим юань) байдаг байна. Манай улсаас Хятадад хямд үнэтэй түлшний хүрэн нүүрс нийлүүлэх боломж бий хэдий ч Хятадын төмөр замын ачаалал ихэссэнтэй холбоотойгоор тээвэрлэх асуудал хүндрэлтэй болоод байна. Хятадын Төмөр замын яамнаас мэдээлснээр төмөр замын тээвэрлэлтийн дараа жилийн төлөвлөгөө оны эцсээр батлагдан гардаг учраас оны дундуур төмөр замын тээврийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах боломж багатай гэж мэдэгдсэн. Тиймээс манай улсаас Хятад улс руу хүрэн нүүрс экспортлох тохиолдолд юуны өмнө тээвэрлэлтийн асуудлаа эцэслэн шийдвэрлэх хэрэгтэй. Коксжсон нүүрсний үнэ Хятад улсад асар хурдацтай нэмэгдэхийн хамт олдоц нь хомс байгаа тул Монголоос Хятад руу коксжсон нүүрсний экспортод тээвэрлэлтийн асуудлыг ямар ч хэлбэрээр шийдвэрлэн худалдаа хийх өргөн боломжтой юм.

10. АНУ, Европын холбоо юаний ханшийг уян хатан болгох чиглэлээр хоёр жилийн турш явуулж буй хүчин чармайлт үр дүнд

хүрээгүй учраас одоо үүнээс өөр хатуу хэлбэрээр Хятад улсад шахалт үзүүлэх боллоо. Ийм учраас Хятад улс энэ оны 2 дугаар хагаст багтаан юаний ханшаа чөлөөлөх магадлал өндөр байна. Жишээлбэл АНУ, Европын Холбооны зүгээс Хятадын экспортын бүх бараанд импортын өндөр татвар тогтоох, улмаар Хятадын экспортын зарим барааг хязгаарлах асуудлыг ДХБ-ын хүрээнд хэлэлцүүлэхээр яригдаж байна. Хэрэв ам.доллартай харьцах юаний ханш олон улсын шинжээчдийн төсөөллийн дагуу 7.9 болж чангарвал манай улсын импорт мөнгөн үнэлгээгээр 6-8 хувиар нэмэгдэх юм. Мөн юаний ханш чангарснаар манай төгрөгийн ханш буурна. Өөрөөр хэлбэл бидний Хятадаас импортлон авдаг барааны ам.доллараас илэрхийлэгдэх үнэлгээ 6-8 хувиар нэмэгдэх болно. Энэ нь манай импортыг үнэтэй болгож улмаар хэрэглээний үнийг нэмэгдүүлнэ. Үүний дүнд ард иргэдийн бодит орлого буурна. Ам.доллар, юань бол манай улсын гадаад худалдааны төлбөр тооцоонд голлон хэрэглэгддэг валют учир энэхүү хоёр валютын ханшны хөдөлгөөн нь манай улсын төлбөрийн балансын тэнцэлд тодорхойлох үүрэг гүйцэтгэдэг. Хятад улс дахь хэрэглээний үнийн болон аж үйлдвэрийн барааны үнийн өсөлт нь манай улсын хэрэглээний үнэд шууд хамааралтай нөлөөдөг учраас бид инфляцийн өсөлтийг тооцохдоо Хятад дахь инфляцийн хөдөлгөөнийг харгалзах хэрэгтэй. Хэдий хэмжээгээр нөлөөлөх, үүнээс уламжлан манай эдийн засгийн дотоод орчилд гарах нөлөөллийг цаашид нарийвчлан тооцох шаардлагатай.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Business Week “China’s Big, Dirty Secret” Tue Feb 1, 2005
2. People’s Daily, Feb 19, 2005 “Let the market fully play its role”
3. Agency France Press Fri Feb 4, 2005 “Tough steps sought as US trade deficit with China hits critical level”
4. Associated Press Sun May 08, 2005 “Tougher Stance on China Currency Adopted”
5. Bloomberg. May 09, 2005 “Yen Drops as China Refrains from loosening Fixed exchange rates”
6. Bloomberg. May 09, 2005 “Yen Drops as China Refrains from loosening Fixed exchange rates”
7. Business Week Mon Jan 31, 2005 “Decoding China’s Yuan Messages”
8. France Press Agency “China to boost refining capacity by a third to handle booming energy demand” Tue Mar 29, 2005